



**“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ  
ГЭРЭЭТ, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН “ТӨХӨМ-Х УРД”  
ТАЛБАЙД 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: Газрын тос хайх-896/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

**Хянасан:**

БОАЖЯ-ны ХБОБЗГ-ын мэргэжилтэн...../ /

**Биелэлтийг тайлагнасан:**

Геологи хайгуулын газрын захирал...../Б.Батцэцэг/

Газрын тосны мэргэжилтэн...../Н.Ганхүлэг/

## АГУУЛГА

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	5
Төслийн зорилго .....	5
Төсөл хэрэгжүүлсэн үе шат.....	7
Дэд бүтэц, зам харилцаа .....	9
Техник, тоног төхөөрөмж .....	9
Ажиллах хүчний мэдээлэл .....	9
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ.....	10
НЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	10
ХОЁР. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	15
ГУРАВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	16
ДӨРӨВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	16
ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	17
ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....	17
ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	17
НАЙМ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....	18
ЕС. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	18
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
АРВАН НЭГ. ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	25
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ.....	26
ДҮГНЭЛТ.....	27
ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУДЫН ЖАГСААЛТ.....	28

## КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монголын Алт” (МАК) ХХК 1993 онд байгуулагдсан бөгөөд үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол Улсын тэргүүлэх компанийн хувьд Үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдлыг чухалчилж Улс эх орныхоо хөгжил дэвшил, эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулах томоохон төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний нэг төсөл нь Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” төсөл юм.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн ажиллаж байна.

### Эрхэм зорилго

Ашигт малтмалын орд нээх, байгалийн баялгийг олборлох, боловсруулах түүнээс эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үр ашигтай бусад үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх замаар нийгмийн баялгийг арвижуулж, урт хугацааны туршид Монгол улсын хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулагч байна.

### Бидний дээдлэх үнэт зүйлс

**Бид-**Дэвшилтэт технологийг эзэмшиж, чадварлаг, эвсэг хамт олныг бүрдүүлэн бизнесийн үр ашгаа нэмэгдүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлнэ.

**Бид-**Үйл ажиллагааныхаа бүх шатанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг дээдэлж, хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөлөлгүй ажиллана.

### Компанийн байгаль орчны бодлого

**Дээдлэх үнэт зүйлс:** “Монголын Алт” (МАК) ХХК нь хэрэгжүүлж буй төсөл, уурхай, үйлдвэрийн байгаль орчны асуудлыг тухайн төслийг боловсруулан бэлтгэх эхний шатнаас эхлэн байнга анхааран ажилладаг. Үйл ажиллагаандаа Монгол улсын болон олон улсын байгаль орчны холбогдох хууль дүрэм, журмыг дагаж мөрдөхөөс гадна төрсөн нутаг, уул усаа хайрлан хамгаалж ажиллахыг компанийн бүх шатны ажилчдад ойлгуулан, таниулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх явдал юм.

**Зорилго:** Компанийн аливаа үйл ажиллагаа, үйлдвэрлэлээс байгаль орчинд үүсч болох нөлөөллийг хамгийн бага утганд байлгах мөн тогтмол уг утгыг бууруулах тал дээр нийт компанийн ажилчид анхааран ажиллах бөгөөд аль болох байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг арилгах буюу “0” утганд дөхүүлэх нь бидний нэн тэргүүний зорилго юм.

**Баримтлах бодлого:** Дээрх зорилгын хүрээнд “Монголын Алт” (МАК) ХХК нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр дараах бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн байгууллага, төрийн бус байгууллагууд болон олон нийттэй хамтран ажиллах боломжийг ирэлхийлэх, хамтран ажиллах;
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны байгууллагууд болон компаниудтай тогтмол харилцаатай хамтран ажиллаж улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх тал дээр анхааран ажиллах;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглах болон дахин боловсруулан ашиглах;
- Ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж шинэ ололт амжилтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх. Мөн хамгийн өндөр үр ашигтай шинэ үеийн техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр байгалийн баялгийн ашиглалтын утгыг дээд түвшинд байлгах;
- Төсөл хэрэгжиж буй орон нутгийн иргэдийн уламжлалт соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах түүнийг өөрийн ажилчидад сурталчилан таниулах;
- Компанийн ажилчидад тогтмол байгаль орчны болоод тухайн орон нутгийн уламжилалт соёлын болон биет өв, ёс заншилын талаархи мэдээлэл, түүний ач холбогдлыг таниулах сургалтуудыг зохион байгуулах;
- Өөрийн компанийн байгаль орчны баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт таниулан ижил шаардлагыг тавих улмаар тэдний байгаль орчны чиглэлийн хариуцлагыг өндөржүүлэх;



## Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” төслийн танилцуулга

- **Төслийн зорилго**




Газрын тосны салбарт эдийн засгийн өндөр үр ашигтай, хүрээлэн буй орчинд ээлтэй орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, дотоодын түүхий эдийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнээр улс орны хэрэгцээг тодорхой хэмжээнд хангах, газрын тос, байгалийн хий дамжуулах хоолой, хадгалах барилга байгууламж бий болгож улмаар тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд газрын тос, байгалийн хийн салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилготой.

“Монголын Алт” (МАК) ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 253 дугаар тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу, Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Цогтцэций, Манлай, Ханхонгор, Мандал-Овоо сумдын нутагт орших “Төхөм-Х урд” талбайд газрын тосны хайгуул, судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” талбайн хэмжээ: 24552,46 км<sup>2</sup>

*Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солбицлууд*

Булангийн цэгийн №	Газар зүйн солбицол	Булангийн цэгийн №	Газар зүйн солбицол
1	N43 49 59.9 E108 19 59.2	13	N44 40 00.1 E105 00 00.0
2	N43 40 00.1 E108 19 59.2	14	N44 40 00.1 E106 29 59.3
3	N43 40 00.1 E108 09 59.0	15	N44 29 26.9 E106 30 00.0
4	N43 40 00.1 E108 00 00.0	16	N44 19 16.0 E107 56 12.8
5	N43 40 00.1 E107 00 00.0	17	N44 40 00.1 E108 05 17.9
6	N43 40 00.1 E106 39 59.0	18	N44 40 00.1 E108 49 59.2
7	N43 49 59.9 E106 39 59.0	19	N44 35 12.1 E108 49 59.2
8	N43 49 59.9 E106 29 58.9	20	N44 30 00.0 E108 49 59.2
9	N44 00 00.0 E106 29 58.9	21	N44 30 00.0 E108 36 31.0
10	N44 00 00.0 E104 29 58.9	22	N44 30 00.0 E108 29 58.9
11	N44 30 00.0 E104 29 58.9	23	N44 10 00.1 E108 29 58.9
12	N44 30 00.0 E105 00 00.0	24	N44 10 00.1 E108 19 59.2





Зураг 1. Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” талбайн байршилн зураг



- **Төслийг хэрэгжүүлсэн үе шат**

Дорноговь аймгийн Мандах сумын Алхантаг багийн нутагт орших Энгэрсухайтын хотгор газрын тосны хайгуулын “Энгэрсухайт-1” цооногийг өрөмдөхөөр төлөвлөн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг АМГТГ-аар хянуулж батлуулсан болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” талбайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар 7 дугаар сард батлуулсан бөгөөд хувийг Дорноговь аймгийн БОАЖГ, Мандах сумын ЗДТГ-т хүргүүлсэн болно.

Газрын тосны өрөмдлөгийн ажил


Газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” талбайн “Энгэрсухайт-1” цооногийн 1991,9 тууш.метр өрөмдлөгийн ажлыг БНХАУ-ын төрийн өмчит “Ди Кю И” интернейшнл /DQE international/ компани 435-1023 тоот гэрээний дагуу 2023 оны 7 дугаар сарын 23-ны өдрөөс 9 дүгээр сарын 4-ний өдрийн хооронд гүйцэтгэсэн.

Өрөмдлөгийн үед өрмийн үзүүрийн багаж буюу цүүцээр бутлагдсан чулуулгийн үртсийг цооногоос гаргах, цэвэрлэх зорилгоор угаалгын шингэнийг ашигладаг. Хурдас чулуулгийн уул-геологийн нөхцөлөөс хамаарч цооногийн өрөмдлөгт хэрэглэх угаалгын шингэнд тавигдах шаардлага ч мөн янз бүр байдаг. Монгол орны нөхцөлд усан суурьтай угаалгын шингэнийг хэрэглэж байна. Угаалгын шингэний үндсэн түүхий эд нь байгалийн гаралтай бентонит, барит ба лигнит шаврууд, хлорт калийн давс, техникийн шүү болон бусад полимер хольцууд болох хор хөнөөл багатай байгалийн гаралтай бүтээгдэхүүнүүдийг ашигладаг.


Цооногийн өрөмдлөг дараах ерөнхий дарааллын дагуу явагддаг. Үүнд:

- Өрөмдлөгийн талбай бэлтгэх
- Өрмийн цамхаг, хээрийн ангийн тээвэрлэлт
- Өрмийн цамхаг угсрах, бэлтгэл ажлууд (Угаалгын шингэн бэлтгэх, өрмийн шингэн хаягдлын сан байгуулах г.м)
- Цооногийн өрөмдлөг (Өрөмдлөгийн явцад шаврын бичиглэл давхар хийнэ)
- Цооногийн ханыг нурахаас урьдчилан сэргийлж бэхэлгээ хийх (бэхэлгээний яндан суурилуулах, цементлэх)
- Цооногт каротажийн судалгаа хийх

Өрөмдлөгийн ажлын үр дүнд Энгэрсухайтын хотгорын гүний бүтцийг зураглаж, газрын тосны хэтийн төлөвийг үнэлэн тодорхойлох боломжтой болно.



Зураг 2. Өрмийн цамхагийн схем зураг



Зураг 3. "Энгэрсухайт-1" цооногийн байршилн зураг

### Дорноговь аймгийн Мандах сум

Мандах сум нь 1924 оны 08 дугаар сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд Алхан тээг, Баянхошуу, Өехий, Сэрвэнбаянхошуу, Төхөм гэсэн засаг захиргааны 5 багтай. Дорноговь аймгийн баруун хэсэгт байрлан, зүүн талаараа Сайхандулаан, урд талаараа Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах баруун талаар Өмнөговь аймийн Манлай, баруун хойд болон хойд талаараа Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил сумтай хиллэдэг болно. Улаанбаатраас 454 км, Дорноговь аймгийн төв Сайншандаас 170 км зайтай. Сумын газар нутгийн нийт хэмжээ 1,266,061.00 га. Сумын нутагт Цагаан суваргын орд, Хөнгөөтийн зэсийн орд, Хоньчийн нүүрсний орд болон алт, усан утаат болор, жонш, өнгөт боржин, занар, гипс, шохой, нүүрс зэрэг ашигт малтмалын арвин нөөцтэй.

- **Дэд бүтэц, зам харилцаа**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам болон төмөр замын технологийн хатуу хучилттай зам “Төхөм-Х урд” талбайн Өгөөмөрийн хотгорын төв хэсгээр дайран өнгөрдөг бөгөөд мөн Сайншанд- Мандах- Манлай- Цогтцэций чиглэлийн төв зам Мандах сумын төвөөр дайран өнгөрдөг. Сумын хэмжээнд 400 хүүхдийн ЕБС, 50 ортой дотуур байр, 10 ортой хүн эмнэлэг, 50 ортой хүүхдийн цэцэрлэг, 200 суудалтай соёлын төв, номын сан, Хаан банк, Төрийн банкны салбар ажилладаг. Мандах сум эрчим хүчний төвийн сүлжээнд бүрэн холбогдсон. Мөн үүрэн телефоны бүх сүлжээнд хамрагдсанаас гадна телевизийн нэвтрүүлгийг DDSH-ийн бүх сувгаар хүлээн авч үзэж байна. Техник технологийн шинэчлэл, хөгжлийн эрин алхам алхамаар урагшилж, сум орон нутгийн иргэдийн аж амьдрал дээшлэн дэлгэрэх бодит нөхцөл бүрдсэн байна.

- **Төсөлд ашиглагдсан техник, тоног төхөөрөмж**

Төсөлд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралтаар оруулсан болно.

- **Ажиллах хүчний мэдээлэл**

Нийт 80 орчим хүн хээрийн анги дээр байрлан ажилласан. Нийт ажилчдын 50 хувь нь Монгол, 50 хувь нь хятад ажилчид байсан. Гэрээт түр ажилчдыг Улаанбаатар хот болон, хөдөө орон нутгаас авч ажиллуулна. Хээрийн ангид:

- Ажилчдын амралтын гэрүүд/контейнер
- Бүрэн тоноглогдсон гал тогоо, бэлтгэл, хүнсний агуулах/контейнер
- Захиалагчийн төлөөлөгчийн контейнер
- Зочин түр ирэгсдийн контейнер

- Ариун цэвэр, угаалгын контейнер
- Иж бүрэн галын цэгүүд

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

2023 онд “Төхөм-Х урд” талбайн Энгэрсухайтын хотгорт хайгуулын 1 ширхэг цооног өрөмдөхөөр төлөвлөсөн.

“Төхөм-Х урд” төслийн хүрээнд байгаль орчныг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхэд дараах зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

- Өрөмдлөгийн ажлын явцад зам ашиглалтын байдалд тогтмол хяналт тавих, олон салаа зам гаргахгүй байх
- Хайгуулын түр кемпийн 190м х 150м харьцаатай хашаан дотор цооногийн цэг байрласан бөгөөд кемпийн хашаан дотор өрөмдлөгийн үйл ажиллагаа явагдсан болно. Улмаар кемпийн хашаан доторх болон хашааны гаднах талбай мөн зам дагуу хог цэвэрлэн, байгаль орчныг хайрлан хамгаалж ажиллах
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ус, хөрс, агаарын хяналт шинжилгээ, хэмжилтийг гүйцэтгэх
- Төслийн хүрээнд ажил гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын байгаль орчны үйл ажиллагаанд хяналт тавих
- Нийт ажилчдад байгаль орчны сургалт, сурталчилгааг явуулах

## **НЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

*Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд:*

- Өрөмдөхөөр төлөвлөсөн “Энгэрсухайт-1” цооногийн цэг нь Цагаансуварга-Оюутолгой чиглэлийн хатуу хучилттай авто замаас урагшаа 6 км-т бөгөөд хатуу хучилттай авто замаас өрмийн кемп хүртэл олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж, батлагдсан маршрутаар хөдөлгөөнийг зохицуулж, хяналт тавьж ажилласан.
- Зам талбайн тэмдэг, тэмдэглэгээг байршуулж хурдны хязгаарыг даган мөрдөж ажилласан.
- Өрөмдлөгийн ажлын хугацаанд хур бороо элбэгтэй байсан тул зам талбайг услах шаардлага гараагүй болно.





Зураг 4. Замын тэмдэг, тэмдэглэгээ



Зураг 5. Бороо хур элбэг байсан тул зам эвдэрсэн байдал



**Усан орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд:**

- Өрөмдлөгийн ажилд шаардлагатай усны хэрэглээг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Нарангийн хоолойн 0606-13-30, 0606-13-34 дугаартай худгаас хангахаар төлөвлөн “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг аймгийн БОАЖГ-аар гаргуулсан.
- Мандах сумтай “Ус ашиглах гэрээ” байгуулж гэрээний дагуу холбогдох төлбөрийг төлсөн. “Ус ашиглуулах дүгнэлт” болон “Ус ашиглах гэрээ”-ний хувийг хавсаргав.
- Өрөмдлөгийн ажлын үед ажилчдын унд ахуйн хэрэглээний усыг аймгийн төвөөс худалдан авч, өрөмдлөгийн усыг Нарангийн хоолойн 0606-13-30, 0606-13-34 дугаартай худгаас гэрээний дагуу авч ашигласан болно.
- Хайгуулын төслийн ажилчдад байгаль орчны сургалтын хүрээнд ус хэмнэлт, зүй зохистой ашиглалт, түүний ач холбогдлын талаар сургалт зохион байгуулсан.



*Зураг 6. Нарангийн хоолойн 0606-13-30 дугаартай худаг. Өрмийн кемпээс 38 км зайтай*


**Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлууд:**

- Өрөмдөхөөр төлөвлөсөн “Энгэрсухайт-1” цооногийн цэг нь Цагаансуварга-Оюутолгой чиглэлийн хатуу хучилттай авто замаас урагшаа 6 км-т бөгөөд хатуу хучилттай авто замаас өрмийн кемп хүртэл олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж, батлагдсан маршрутаар хөдөлгөөнийг зохицуулж, хяналт тавьж ажилласан бөгөөд орон нутгийн замыг ашигласан болно.
- Өрөмдлөгийн ажлын үед хүнс тээврийн болон усны машин, бохирын машин, хогны машины жолооч нарт батлагдсан зам маршрутын дагуу хөдөлгөөнд оролцож



байхыг зөвлөж мөрдлөг болгосон. Мөн ачаа тээврийн машин болон усны машин тогтсон маршрутын дагуу хөдөлгөөнд оролцож байгаад хяналт тавьж ажилласан.

- Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж замын маршрут зураг гарган ашиглах, өрөмдлөгийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалыг нэг цуваагаар нэг замаар тээвэрлэн авч ирсэн болно.
- Сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулсан бөгөөд МАК “Цагаан Суврага”-уурхайн хогийн цэгт хог хаягдлыг зөөвөрлөн авчирч устгадаг байсан. Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээг хавсралтаар оруулав.
- Өрмийн түр кемпэд хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг байршуулсан бөгөөд кемпийн хашаан дотор торон хашаа бүхий хог хаягдлын цэгийг байгуулсан.
- Өрөмдлөгийн ажлын үед кемпийн бохирыг соруулан МАК “Цагаан Суврага” уурхайн бохирын цэг дээр зөөвөрлөн авчирч устгадаг байсан.
- Хөрсөнд ямарч төрлийн хог хаягдлыг устгаагүй болно.
- Өрмийн шингэн хаягдлын сангийн (25м x 12м x 3,5м) нүхийг тусгай зориулалтын плёнкоор доторлож, хөрсөнд шингээхгүй байхаар хийж гүйцэтгэсэн.



Зураг 7. ZJ30DB загварын өрмийн машин



*Зураг 8. Өрмийн тоног төхөөрөмжийн тээвэр болон шингэн хаягдлын сангийн доторлогоо*  
**Ургамлын бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд:**

- Мандах сумын засаг даргын А/95 тоот захирамжийн дагуу Түр кемпийн зөвшөөрөл авсан бөгөөд кемпийн 190 х 150м харьцаатай хашаан дотор өрөмдлөгийн үйл ажиллагаа явагдсан болно. Кемпийн зөвшөөрлийн захирамжийг хавсралтаар оруулав.
- Нийт ажилчдад явуулсан Байгаль орчны сургалтаар Байгаль орчныг хамгаалах тухай хууль, ан агнуурын хууль, мөн өрөмдлөгийн ажлын үед кемпийн хашаанаас гарахгүй, ил задгай хог хаяхгүй, ургамал таслахгүй, ан амьтан үргээхгүй, агнахгүй, байгаль орчныг хайрлан хамгаалж ажиллахыг хатуу анхааруулж сануулсан болно.
- Өрөмдлөгийн ажилд шаардлагатай техник хэрэгслийг (50 тонны кран, усны машин, бохирын машин, хогны машин, үйлчилгээний жижиг машин гэх мэт) гэрээгээр авч ажиллуулсан бөгөөд кемп дээр засвар үйлчилгээ, тос масло солихыг хатуу хориглосон тул ямар нэгэн техникийн засвар үйлчилгээ хийгээгүй болно.



- Өрөмдлөг, кемп, тээврийн хэрэгсэл, ажилчдын үйл ажиллагаанд МАК компанийн харуул хамгаалалтын алба хяналт тавьж ажилласан болно.



*Зураг 9. Түр кемтийн хашаа болон хогийн цэг*


## **ХОЁР. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Бид өрөмдлөгийн ажлыг явуулахдаа компанийн байгаль орчныг хамгаалах бодлого мөн байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулж түүний унаган төрхийг алдагдуулахгүй байх, эх нутаг газар шороогоо хайрлан хамгаалж, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх холбогдох хууль дүрэм, стандарт заавруудыг чандлан дагаж мөрдөхийн зэрэгцээ сум орон нутгийн ЗДТГ, ард иргэдтэй ажил төрлөө уялдуулж нягт хамтран ажилласан болно.

Өрөмдлөгийн ажлын хугацаанд түр кемп, өрмийн талбай, зам дагуу тогтмол цэвэрлэж байсан бөгөөд ажил дууссаны дараа Мандах сумын ЗДТГ-т кемпийн газар болон өрмийн талбайг танилцуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны 2 сарын 22-ны өдрийн А50/А31 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтын дагуу акт үйлдэн болно.

“Энгэрсухайт-1” цооногийн шингэн хаягдлын санг салбартаа тэргүүлэгч, туршлагатай мэргэжлийн компани болох Монбаг ХХК барьж байгуулсан.

Өрмийн шингэн хаягдлын сангийн нүхийг холбогдох стандартын шаардлага хангасан шингэн үл нэвчүүлэх материалаар доторлосон бөгөөд хаягдлын сангийн шингэн нь байгаль орчинд алдагдал гаргахгүй, тоосжилт үүсгэхгүй хийцтэйгээр байгуулж, хамгаалалтын торон хашааг барьсан.



Зураг 10. Шингэн хаягдлын сан

Тус шингэн хаягдлын санг 2024 оны хайгуулын жилд хийж гүйцэтгэх цооногийн туршилт, үйлчилгээний ажилд ашиглах тул Монгол Улсын стандарт MNS 6200:2010-ын 6.6 “Өрөмдлөгийн шингэний хаягдлын санг цооног өрөмдлөгийн үйл ажиллагаа дууссанаас хойш 12 сар, тусгай зориулалттай шингэн хаягдлын санг тухайн технологи үйл ажиллагаа дууссанаас хойш 6 сарын дотор техникийн нөхөн сэргээлт хийнэ.” гэж заасны дагуу техникийн нөхөн сэргээлтийг хийлгүй дахин ашиглахаар төлөвлөн үлдээсэн. Ажил гүйцэтгэсэн талбайд байнгын харуул хамгаалалттай байгаа болно.

## **ГУРАВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Дүйцүүлэн хамгаалах ажил байхгүй болно.

## **ДӨРӨВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Өрөмдлөгийн ажлын үед талбайд нөлөөлөлд өртөж, нөхөн олговор олгох орон нутгийн айл байхгүй болно.



## ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өрөмдлөгийн ажлын үед археологи, палеонтологийн олдвор илрээгүй бөгөөд үйл ажиллагааны явцад олдвор илэрсэн тохиолдолд Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу дагаж мөрдөн ажилласан.

### ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нийт ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- Өрөмдлөгийн ажлын талаар орон нутгийн иргэд болон ажиллагсадад дэлгэрэнгүй мэдээлэл өгч танилцуулсан бөгөөд заавар зөвлөмж өгсөн.
- Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй ослоос сэргийлсэн сургалтуудыг зохион байгуулсан.
- Ажиллагсадыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр бүрэн хангасан.



Зураг 11. Өрөмдлөгийн ажлын нээлт, заавар зөвлөгөө, сургалт

### ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу ажилласан бөгөөд МАК “Цагаан Суврага” уурхайн хогийн цэгт хог хаягдлыг зөөвөрлөн авчирч устгадаг байсан ба тогтмол хяналт тавьж ажилласан. *(Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээний хуулбарыг хавсралтаар оруулав)*
- Өрмийн түр кемпэд хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг байршуулсан бөгөөд кемпийн хашаан дотор торон хашаа бүхий хог хаягдлын цэгийг байгуулсан.

- Өрөмдлөгийн ажлын үед кемпийн бохирыг соруулан МАК “Цагаан Суврага” уурхайн бохирын цэг дээр зөөвөрлөн авчирч устгадаг байсан.
- Хөрсөнд ямарч төрлийн хог хаягдлыг устгаагүй болно.
- Өрөмдлөгийн түр кемпийн хашаа, хашааны гаднах талбай болон зам дагуу тогтмол цэвэрлэгээ хийж, хог хаягдлыг түүж ажилласан.

## **НАЙМ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Дорноговь аймгийн Мандах сумын Алхантаг багийн иргэдийн нийтийн хурал 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр багийн төв дээр зохион байгуулагдсан бөгөөд тус хурлаар нутгийн ард иргэд, орон нутгийн удирдлагуудад хайгуулын ажлын төлөвлөгөөг танилцуулан холбогдох мэдээллийг өгч, хайгуулын ажлын төлөвлөгөө болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хүлээлгэн өгсөн болно.

## **ЕС. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Өрөмдлөгийн ажлын хугацаанд сум, орон нутгийн малчин ард иргэд, төрийн байгууллагад үнэн, зөв, бодит мэдээлэл өгч байсан бөгөөд ажил дууссаны дараа Мандах сумын ЗДТГ, малчин айл өрхөд байгаль орчыг хамгаалах талаар хийсэн ажил, өрмийн түр кемпийн газрыг хүлээлгэн өгч, акт үйлдсэн болно.

Нийгмийн хариуцлагын хүрээнд газрын тосны хайгуулын “Төхөм-Х урд” талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Мандах сумын орон нутгийг хөгжүүлэх санд 242,5 сая төгрөгийг хандивласан болно. Мөн Алхантаг багийн малчин Нэргүйн эзэмшилийн худгийн ойр орчмын нягтаршиж, овойж товойсон гадаргууг хусаж, засаж өгсөн болно.



*Зураг 12. 1970 оноос хойш хусаагүй байсан талбайг хусаж, засав*

## АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лаборатори мөн “Ханлаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторитай хамтран ажилласан бөгөөд өрмийн түр кемпийн 6 цэгээс хөрсний дээж, агаарын дээж, Нарангийн хоолойн 0606-1334 дугаартай худгаас усны дээж авч шинжилгээнд хамруулсан.

*Хүснэгт 2. Дээжний мэдээлэл*

№	Дээжний төрөл	Дээжний дугаар	Дээж авсан байршил	Дээж авсан цэг
1	Хөрс	№1	Ажилчдын түр сууц	N43 45 47.9 E108 16 11.9
		№2	Ариун цэврийн өрөө /00/	N43 45 48.8 E108 16 11.3
		№3	Гал тогоо	N43 45 49.6 E108 16 10.0
		№4	Авто зогсоол	N43 45 50.0 E108 16 09.1
		№5	Хогийн цэг	N43 45 50.7 E108 16 09.8
		№6	Өрмийн талбай	N43 45 46.4 E108 16 12.2
2	Ус	№1	Нарангийн хоолой-Худаг №0606-1334	N43 59 34.8 E108 26 10.5
3	Агаар	№1	Ажилчдын түр сууц	N43 45 48.8 E108 16 11.1
		№2	Ариун цэврийн өрөө /00/	N43 45 49.2 E108 16 11.2
		№3	Гал тогоо	N43 45 49.5 E108 16 10.1
		№4	Авто зогсоол	N43 45 50.2 E108 16 09.0
		№5	Хогийн цэг	N43 45 50.8 E108 16 09.9
		№6	Өрмийн талбай	N43 45 46.4 E108 16 12.3







Зураг 13. Орчны хяналт шинжилгээний ажил

## Дээжний шинжилгээний хариу

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

### ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он /№ : 2023/75  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “МОНГОЛЫН АЛТ” ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Ч. Түмэннаст /Лабораторийн инженер/  
Сорьцын тоо, төрөл : SO<sub>2</sub>-6, NO<sub>2</sub>-6, Тоос-6  
Хүлээн авсан огноо : 2023.08.12  
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг, Мандах сум  
Шинжилсэн огноо : 2023.08.14  
Хуудасны тоо : 2

#### Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Хүхэрлэг хий SO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл NO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>	Нийт тоосны агууламж мг/м <sup>3</sup>
1	Ажилчдын түр сууц N 43°45'48.8 E 108°16'11.1	0.021	0.014	0.005
2	Ариун цэврийн өрөөний орчин N 43°45'49.2 E 108°16'11.2	0.022	0.011	0.008
3	Гал тогооны орчин N 43°45'49.5 E 108°16'10.1	0.022	0.022	0.016
4	Авто зогсоол /том машин/ N 43°45'50.2 E 108°16'09.0	0.0119	0.006	0.027
5	Ахуйн хог хаягдлын цэг N 43°45'50.8 E 108°16'09.9	0.018	0.006	0.007
6	Өрөмдлөгийн талбай N 43°45'46.4 E 108°16'12.3	0.025	0.017	0.009
ЗДХ	MNS4585:2016	0.450	0.200	0.500

Шинжилгээ гүйцэтгэсэн Лабораторийн инженер: *Ч. Түмэннаст* Ч. Түмэннаст

Хянаж баталгаажуулсан УЦУОШТөвийн дарга: *Т. Азбаяр* Т. Азбаяр



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.





**ХАНЛАБ ХХК**  
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба  
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр  
Утас: 70109968, 99995316  
<http://www.khanlab.mn>



## ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: МАК ХХК

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,  
ТОО

Ус, 1

ЗАХИАЛГА №: 2023/1274-2

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.08.14

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.08.28

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.  
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

Чанарын менежер:



Д.Пүрэвжаргал

*Хамтран ажилласан таньд талархлаа.*

ЗАХИАЛГА №: 2023/1274-2

ДЭЭЖИЙН ДУГААР: Нараангийн хоолойн худаг №0606-1334

ДЭЭЖИЙН БАЙРШИЛ: N-435934.8 E-1082610.5

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-14840

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 0900:2018/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	8.15	6.5-8.5	MNS ISO 10523:2001
2	Кали ( $K^+$ )	мг/л	1.64	-	MNS 5465:2005
3	Натри ( $Na^+$ )	мг/л	361.6	200.0	
4	Кальци ( $Ca^{2+}$ )	мг/л	13.49	100.0	MNS ISO 2572:1999
5	Магни ( $Mg^{2+}$ )	мг/л	4.75	30.00	
6	Аммоний ( $NH_4^+$ )	мг/л	<0.10	1.50	MNS ISO 7150-1:2006
7	Хлорид ( $Cl^-$ )	мг/л	238.2	350.0	MNS ISO 9297:2005
8	Сульфат ( $SO_4^{2-}$ )	мг/л	210.8	500.0	MNS 3652.4:1984 MNS ISO 11885:2011
9	Нитрит ( $NO_2^-$ )	мг/л	0.06	1.00	MNS 4431:2005
10	Нитрат ( $NO_3^-$ )	мг/л	2.16	50.00	MNS ISO 7890-3:2001
11	Карбонат ( $CO_3^{2-}$ )	мг/л	1.50	-	MNS ISO 9963-1:2005
12	Гидрокарбонат ( $HCO_3^{2-}$ )	мг/л	308.1	-	
13	Нийт хатууллаг	мг-экв/л	1.06	7.00	
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	1030	1000	MNS 4423:1997
15	Цахиурын хүчил, $H_2SiO_3$	мг/л	11.73	-	
16	Исэлдэх чалвар / $KMnO_4$ /	мг $O_2$ /л	3.12	-	MNS ISO 4889:1999
17	Фосфат, $PO_4^{3-}$	мг/л	<0.05	3.5	MNS ISO 6878:2001
18	Фтор, $F^-$	мг/л	2.05	0.7-1.5	MNS ISO10359-1:2002
19	Хүхэргүстөрөгч, $H_2S$	мг/л	<0.10	0.1	
20	Чөлөөт хлорид, $Cl_{хол}$	мг/л	<0.10	0.2-0.3	MNS ISO 7393-1:2001
21	Бундгар	NTU	<10.0	1.5	
22	Мөнгө, Ag	мг/л	<0.01	0.1	
23	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.50	
24	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
25	Бор, B	мг/л	1.45	2.40	
26	Бари, Ba	мг/л	0.01	0.70	
27	Берелли, Be	мг/л	<0.001	0.0002	
28	Кадми, Cd	мг/л	<0.005	0.003	
29	Кобальт, Co	мг/л	0.001	-	
30	Хром, Cr	мг/л	<0.005	0.05	
31	Зэс, Cu	мг/л	<0.02	2.0	MNS (ISO) 11885:2011
32	Төмөр, Fe	мг/л	<0.03	0.3	
33	Марганец, Mn	мг/л	<0.01	0.1	
34	Молибден, Mo	мг/л	0.05	0.07	
35	Никель, Ni	мг/л	0.005	0.02	
36	Харгугалга, Pb	мг/л	<0.01	0.01	
37	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.02	
38	Селен, Se	мг/л	<0.05	0.04	
39	Стронци, Sr	мг/л	0.33	2.00	
40	Уран, U	мг/л	<0.10	0.03	
41	Цайр, Zn	мг/л	0.05	5.0	
42	Цианид, $CN_{free}$	мг/л	<0.002	0.01	
43	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.001	







**ХАНЛАБ ХХК**  
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзандамба  
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр  
Утас: 70109968, 99995316  
<http://www.khanlab.mn>



**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

ЗАХИАЛГА №: 2023/1274-1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **МАК ХХК** /ТӨХӨМ-Х УРД талбай/ ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: **Хөрс, 6**

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖ АВСАН ЦЭГ	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг				
				Na	Ca	Mg	K	Fe <sub>нийт</sub>	As	Ba*	Be	Bi	Cd
1	Л-14834	Ажилчдын түр сууц	N43 45 47.9 E108 16 11.9	2.67	1.45	0.58	1.98	3.21	13.56	875.3	1.13	<10.0	<1.0
2	Л-14835	Ариун цэврийн өрөө /ОО/	N43 45 48.8 E108 16 11.3	2.81	1.00	0.54	1.85	2.70	8.72	967.9	1.08	<10.0	<1.0
3	Л-14836	Гал тогоо	N43 45 49.6 E108 16 10.0	2.64	1.07	0.66	1.61	3.03	10.03	899.1	1.09	<10.0	<1.0
4	Л-14837	Авто зогсоол	N43 45 50.0 E108 16 09.1	2.62	2.46	0.54	1.88	2.98	<5.0	2178	1.08	<10.0	<1.0
5	Л-14838	Хогийн цэг	N43 45 50.7 E108 16 09.8	2.68	1.93	0.46	2.46	2.99	<5.0	2388	1.02	<10.0	<1.0
6	Л-14839	Өрмийн талбай	N43 45 46.4 E108 16 12.2	2.61	1.16	0.51	1.34	2.47	<5.0	856.1	1.10	<10.0	<1.0
MNS5850: 2019				-	-	-	-	-	20.00	-	-	-	3.00

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖ АВСАН ЦЭГ	ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	Л-14834	Ажилчдын түр сууц	N43 45 47.9 E108 16 11.9	14.85	41.16	47.59	6.81	16.24	795.9	<5.0	27.01	977.1	11.46
2	Л-14835	Ариун цэврийн өрөө /ОО/	N43 45 48.8 E108 16 11.3	13.50	29.25	39.45	6.95	14.90	864.3	<5.0	16.66	985.5	9.48
3	Л-14836	Гал тогоо	N43 45 49.6 E108 16 10.0	14.67	39.18	41.65	7.54	15.61	1108	<5.0	18.89	812.6	9.97
4	Л-14837	Авто зогсоол	N43 45 50.0 E108 16 09.1	<5.0	13.78	51.47	8.37	15.82	1151	<5.0	6.09	284.3	<5.0
5	Л-14838	Хогийн цэг	N43 45 50.7 E108 16 09.8	5.30	11.37	59.41	12.51	14.26	393.6	<5.0	7.59	280.6	<5.0
6	Л-14839	Өрмийн талбай	N43 45 46.4 E108 16 12.2	5.56	11.20	38.32	7.69	14.33	470.0	<5.0	7.96	288.7	5.20
MNS5850: 2019				50.00	150.0	100.0	-	-	-	5.0	150.0	-	100.0



№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖ АВСАН ЦЭГ	ЭЛЕМЕНТ, мг/кг								
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*	
1	Л-14834	Ажилчдын түр сууц	N43 45 47.9 E108 16 11.9	<10.0	<5.0	385.4	3110	122.5	8.75	49.14	68.36	
2	Л-14835	Ариун цэврийн өрөө /ОО/	N43 45 48.8 E108 16 11.3	<10.0	<5.0	397.2	2994	105.9	9.21	45.66	67.59	
3	Л-14836	Гал тогоо	N43 45 49.6 E108 16 10.0	<10.0	<5.0	372.6	3326	122.6	9.87	49.45	71.59	
4	Л-14837	Авто зогсоол	N43 45 50.0 E108 16 09.1	<10.0	<5.0	484.5	2807	117.0	9.70	16.89	67.25	
5	Л-14838	Хогийн цэг	N43 45 50.7 E108 16 09.8	<10.0	<5.0	521.1	2648	112.2	10.84	20.16	77.60	
6	Л-14839	Өрмийн талбай	N43 45 46.4 E108 16 12.2	<10.0	<5.0	419.4	2401	82.51	9.19	20.93	67.13	
<i>MNS5850: 2019</i>						<i>10.00</i>	<i>800.0</i>	<i>-</i>	<i>150.0</i>	<i>-</i>	<i>300.0</i>	<i>-</i>
Чанарын менежер:				Д. Пүрэвжаргал								

Тайлбар: \*-Бүрэн задрахгүй. /Хагас тоон утга/

Шинжилгээнд ирүүлсэн дээжийг 1 сар хүртэл хугацаагаар хадгална.

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна. Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.08.14

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.08.18

ХУУДАСНЫ ТОО: 2

*Хамтран ажилласан танд талархлаа.*

Хуудас 2-2

## АРВАН НЭГ. ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Газрын тосны хайгуулын Энгэрсухайт-1 цооногийн өрөмдлөгийн ажилд 10 нэр төрлийн 72,28 тонн химийн бодис ашигласан бөгөөд эдгээр бодисууд нь химийн хорт болон аюултай бодис биш болно.

*Хүснэгт 3. Өрөмдлөгийн ажилд ашигласан химийн бодисны жагсаалт*

№	Бодисын нэршил	Бодисын олон улсын нэршил	Химийн томъёо	Хэмжээ (Тн)
1	Барийн сульфат	Barite	BaSO <sub>4</sub>	46
2	Бентонит	betonite	Al <sub>2</sub> O <sub>3</sub> ·4SiO <sub>2</sub> ·3H <sub>2</sub> O	3
3	Аммонийн давс	Hydrolized Polyacrinitrile Ammonium	NH <sub>4</sub> (C <sub>4</sub> O <sub>2</sub> NH <sub>3</sub> ) <sub>n</sub>	1.7
4	Цагаан асфальт /Өрөмдлөгийн шингэнд зориулсан нурултын эсрэг бодис/	Anti collapse agent for drilling fluid Non-Floures cent white ashpalt NFA-25	C <sub>18</sub> H <sub>36</sub> O(CH <sub>2</sub> O) <sub>10</sub> C <sub>17</sub> H <sub>34</sub> O <sub>2</sub>	6.3
5	Өрөмдлөгийн шингэнтэй хамт хэрэглэдэг Цвиттерионы полимер бүрхүүл	Zwitterionic polymer encapsulation used with drill fluid	(NH <sub>2</sub> CHNH <sub>2</sub> CHCOOHNH <sub>2</sub> ) <sub>n</sub>	1
6	Калийн гидроксид	Postassium Hydroxide	KOH	2.6
7	Үйлдвэрийн натрийн карбонат	insdustrial sodium carbonate	Na <sub>2</sub> CO <sub>3</sub>	0.58
8	Зуурамтгай чанар бууруулагч	Diluent Viscosity Reducer-DJ-C for Drilling fluids	(C <sub>3</sub> H <sub>3</sub> NaO <sub>2</sub> ) <sub>n</sub>	2.8
9	Кардоксиметил целлюлоз LV-СМС	Cardoxymethyl cellulose LV-СМС	(C <sub>6</sub> H <sub>7</sub> O <sub>2</sub> (OH) <sub>2</sub> OCH <sub>2</sub> COONa) <sub>n</sub>	2
10	Цооногийн хана тогтворжуулагч	KFH-1 Fluid loss reducer to prevent wellbore collapse	C <sub>3</sub> H <sub>6</sub> O <sub>2</sub> NCO <sub>2</sub> HnM	6.3
	Нийт			72.28

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

*Хүснэгт 4. БОМТ хэрэгжүүлэхэд гарсан нийт зардал*

№	Үйл ажиллагтаны төрөл	Зардлын хэмжээ (төг)	
1	Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын төлбөр	450 000
		Ариутгал, халдваргүйжүүлэлт	2 000 000
		Өрмийн түр кемпийн ойр орчим, зам дагуу байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил	10 000 000
		Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын зардал	1 834 260
		Байгаль орчны сургалт	1 000 000
2	Удирдлага, менежментийн болон бусад зардал	Орон нутгийн уулзалт	2 540 000
<b>Нийт зардал</b>		<b>17 824 260</b>	

## ДҮГНЭЛТ

“Монголын алт” (МАК) ХХК нь Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн дагуу Байгаль хамгааллын дүрэм журмыг чанд сахин, стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тогтмол гүйцэтгэсээр ирлээ.

Бид компанийн байгаль орчныг хамгаалах бодлого мөн Монгол улсын болон олон улсын байгаль орчны хууль, журмыг дагаж мөрдөн төрсөн нутаг, уул усаа хайрлан хамгаалж ажиллах нь бидний үнэт зүйлс гэдгийг ойлгон, ухамсарлаж бүх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Өрөмдлөгийн ажлын хугацаанд түр кемп, замын ойр орчмыг цэвэрлэн, байгаль орчноо хайрлан хамгаалсан бөгөөд ажил дууссаны дараа Мандах сумын ЗДТГ-т кемпийн газрыг хүлээлгэн өгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны 2 сарын 22-ны өдрийн А50/А31 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтын дагуу акт үйлдсэн болно.

Тус төслийн хүрээнд олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж зөвхөн орон нутгийн замыг ашиглаж байсан болно. Өрөмдлөгийн ажлын үед МАК компанийн газрын тосны мэргэжилтэн, Мандах сумын ЗДТГ, Алхантаг багийн малчин өрх хяналт тавьж ажилласан.

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдлыг чухалчилж дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгаатай холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд газрын тосны хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд газрын тосны талаарх төрийн бодлогыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажилласан Мандах сумын ЗДТГ, нутгийн ард иргэдэд гүн талархал илэрхийлье.



## ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУДЫН ЖАГСААЛТ

- “Монголын Алт” (МАК) ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- “Төхөм-Х урд” талбайн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны 2 сарын 22-ны өдрийн А50/А31 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт
- Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээ
- Орон нутагтай байгуулсан усны гэрээ
- Мандах сумын Засаг даргын захирамж А/95
- Өрөмдлөгийн ажилд ашигласан техник, тоног төхөөрөмжийн жагсаалт



Хууль зүйн сайдын 2016 оны  
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000209623

2006.02.17

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011071054

/ Хувийн хэргийн дугаар /

2095025

/ Регистрийн дугаар /

Монголын алт МАК

Хязгаарлагдмал хариуцлагатай  
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

1996.08.30

/ он, сар, өдөр /

